

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2017.02.22

Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**1.1. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ**

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, салбарын үйл ажиллагааг дэмжих, нэгдсэн цогц бодлогын хүрээнд Хорооноос Банк бус санхүүгийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр 2016 онд дараах журам, заавар, аргачлалыг шинэчлэн баталлаа. Үүнд:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар:

ББСБ-уудын үйл ажиллагааны цар хүрээг өрөгжүүлэх, үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг хөнгөвчлөх зорилгоор Хорооны 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар"-ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмаар ББСБ-уудыг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан 3 ангилж, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл шаардлагуудыг нарийвчлан тодорхойлж, зохицуулалтын хэм хэмжээг тогтоосон.

Тус журам батлагдсантай холбогдуулан Хорооны 2008 оны 78 дугаар тогтоолоор баталсан "Итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам", 162 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд журам боловсруулах заавар", 186 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам", 2011 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх журам", 2012 оны 148 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам"-ыг тус тус хүчингүй болгосон.

Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай:

ББСБ-уудын эрсдэл даах чадварыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, үйлчилгээний өртгийг бууруулах, санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх Хорооны нэгдсэн бодлогын хүрээнд Хорооны 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тодорхой хугацаанд үе шаттайгаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам:

ББСБ-ын өөрийн хөрөнгө, эх үүсвэрийн зөв оновчтой бүтцийг бий болгох, эрсдэл даах чадварыг сайжруулах зорилгоор Хорооны 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 147 дугаар тогтоолоор "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ыг шинэчлэн баталж, Хорооны 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 269 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус журмаар ББСБ-д мөрдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан ялгавартай тогтоож, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс зохицуулалтын байгууллагууд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг улирал бүр, итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн тайлан, зээл олголт, эргэн төлөлт, хүүгийн судалгааны тайлан, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тайлан, гадаад валют арилжааны мэдээг сар бүр тогтоосон хугацаанд Хороонд ирүүлж байхаар шийдвэрлэсэн.

1.2 САЛБАРЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх ББСБ-уудын тоо 2016 оны жилийн эцэст 518-д хүрлээ. Энэ нь 2006 оны мөн үетэй харьцуулахад 2.7 дахин, оны эхнээс 15.1 хувиар өссөн үзүүлэлт юм.

(Дүрслэл 1)



Тайлант жилд Хорооны хуралдаанаар 72 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 4 банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгох, 1 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

(Хүснэгт 1)

№	Тайлант он	Тусгай зөвшөөрөл				Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
		шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	сэргээсэн	
1	2006 он	2	24	-	-	139
2	2007 он	10	12	-	-	137
3	2008 он	10	15	-	-	132
4	2009 он	56	11	15	9	177
5	2010 он	20	15	20	7	182
6	2011 он	32	19	14	8	195
7	2012 он	23	6	4	2	212
8	2013 он	54	3	3	1	263
9	2014 он	120	5	5	1	378
10	2015 он	80	8	6	5	450
11	2016 он	72	4	-	1	518

Түүнчлэн тайлант жилд Хороо зээлийн үйл ажиллагаа, гадаад валютын арилжаа, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг тус бүр хоёр ББСБ-д, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг тус бүр нэг ББСБ-д, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг тус бүр дөрвөн ББСБ-д нэмж олгох, тус бүр нэг компанийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна.

Харин нэр бүхий 3 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны санаачлагаар, 1 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг өөрийн хүсэлтээр хүчингүй болгох, 1 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг сэргээх арга хэмжээ авсан байна.

Тайлант оны байдлаар давхардсан тоогоор нийт ББСБ-ын 89.4 хувь буюу 463 ББСБ зээлийн үйл ажиллагаа, 27.8 хувь буюу 144 ББСБ гадаад валютын арилжаа, 6.4 хувь буюу 33 ББСБ

хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 5.4 хувь буюу 28 ББСБ итгэлцлийн үйлчилгээ, 4.2 хувь буюу 22 ББСБ факторингийн үйлчилгээ, 3.1 хувь буюу 16 ББСБ төлбөрийн баталгаа гаргах, 2.3 хувь буюу 12 ББСБ цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 0.4 хувь буюу 2 ББСБ богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээг давхардсан тоогоор тус тус эрхэлж байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан эрхлэх үйл ажиллагааны төрлөөр ББСБ-уудыг ангилвал: (Хүснэгт 4)

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өсөлт	
		2015	2016	тоо	хувь
	Нийт ББСБ	450	518	68	15.1
1	Зээлийн үйл ажиллагаа	380	463	83	21.8
	<i>Үүнээс: Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	285	343	58	20.4
2	Факторонгийн үйлчилгээ	18	22	4	22.2
3	Төлбөрийн баталгаа гаргах	15	16	1	6.7
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	2	2	100
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	12	6	100
6	Гадаад валютын арилжаа	136	144	8	5.9
	<i>Үүнээс: Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	52	51	(1)	(1.9)
7	Итгэлцлийн үйлчилгээ	26	28	2	7.7
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2	-	-
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	27	33	6	22.2

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны төрлөөс нийт ББСБ-ын 66.2 хувь буюу 343 ББСБ зээлийн үйл ажиллагаа, 9.8 хувь буюу 51 ББСБ гадаад валютын арилжааг дагнан эрхэлж байгаа нь хамгийн их эрэлттэй үйлчилгээ болох нь харагдаж байна.

Он дамжин үргэлжилсэн эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэргүй байдлаас шалтгаалан эдийн засгийн идэвхижил саарч, гадаадын хөрөнгө оруулалтын гарах урсгал нэмэгдэн Монгол улсын эдийн засагт хүндрэл тулгарч байгаа хэдий ч салбарт оролцогчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 68 компани буюу 15.1 хувиар, тэр дундаа зээлийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 83 компаниар буюу 21.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарлаа.

Мөн тусгай зөвшөөрөлтэй төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэгчдийн тоо 1 дахин, факторингийн үйлчилгээ, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээ эрхлэгчдийн тоо тус тус 22.2 хувиар нэмэгдсэн хэдий ч дээрх үйлчилгээг төдийлөн эрхлэхгүй байна.

2016 онд Хорооны даргын тушаалаар 114 ББСБ хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх, 33 ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд давхардсан тоогоор 143 ББСБ хаяг, байршил, 59 ББСБ гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийг Хороонд бүртгүүлсэн байна.

2016 оны дөрөвдүгээр улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 518 ББСБ-аас 498 ББСБ /96.1%/ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд харин нэр бүхий 20 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр болон өмнөх үеийн санхүүгийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан болно.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 787.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 26.3 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд ББСБ-уудын өөрийн хөрөнгө 154.3 тэрбум төгрөгөөр буюу 26.7 хувиар, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгө 132.1 тэрбум төгрөгөөр буюу 42.8 хувиар өссөн нь голчлон нөлөөлж байна. Активын өсөлтийг 2014 оны мөн үетэй харьцуулахад 7.1 нэгж хувиар буурсан бол 2015 оны мөн үеэс 7.8 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа.

ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгө нь санхүүгийн зах зээлийн 95 гаруй хувийг дангаар бүрдүүлдэг банкны салбарын 68.8 хувьтай тэнцэж байгаагаас үзэхэд хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхэлж буй онцлогтой холбоотой. Улмаар бизнесийн *ББСБ-уудын 2016 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга*

идэвхижил саарч, эдийн засагт гадаад, дотоод орчны нөлөөгөөр аливаа эрсдэл үүсэхэд өөрийн хөрөнгөөрөө эрсдэлээ бүрэн хариуцах боломжтой болохыг харуулж байна.

Тайлант жилд ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 68 компаниар буюу 15.1 хувиар, хувьцаа эзэмшигчдийн тоо 120-оор буюу 13.0 хувиар, салбарт ажиллагсдын тоо 120 хүнээр нэмэгдэж 2115-д хүрсэн байна.

Тайлант хугацааны голлох статистик үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харуулбал:

(Хүснэгт 6)


(мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2015	2016	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
	Нийт ББСБ-ын тоо	450	518	68	15.1
	<i>Үүнээс: хөдөө орон нутагт</i>	50	60	10	20.0
	Харилцагчдын тоо	636,341	592,461	(43,880)	(6.9)
	Хувьцаа эзэмшигчдийн тоо	922	1,042	120	13.0
	Ажиллагсдын тоо	1,995	2,115	120	6.0
	Салбар нэгжийн тоо	116	124	8	6.9
	<i>Үүнээс: Улаанбаатар хотод</i>	86	92	6	7.0
	<i>Үүнээс: Хөдөө орон нутагт</i>	30	32	2	6.7
	Төлөөлөгчийн газар	4	4	-	-
	Нийт хөрөнгө	623,172,524.1	787,172,010.1	163,999,486.0	26.3
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувиар/</i>	3.0%	3.1%	0.1%	
	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	391,235,479.1	478,175,223.3	86,939,744.2	22.2
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувиар/</i>	3.4%	3.9%	0.5%	
	Нийт өөрийн хөрөнгө	424,210,836.2	578,491,202.8	154,280,366.6	36.4
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувиар/</i>	16.8%	18.6%	1.8%	
	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	308,451,260.0	440,547,491.2	132,096,231.2	42.8
	<i>Банкны салбартай харьцуулахад /хувиар/</i>	65.6%	68.8%	3.2%	

Тайлант жилд банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт актив банкны салбарын 3.1 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 3.9 хувь, өөрийн хөрөнгө 18.6 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө 68.8 хувьтай тус тус тэнцэж байна. Энэ нь оны эхнээс 0.1-3.2 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хороо байгуулагдсан үеэс буюу 2006-2016 оныг хүртэлх хугацааны тоо баримтаас үзэхэд 2014 оныг хүртэлх хугацаанд ББСБ-уудын тоо, харилцагчдын тоон үзүүлэлт харгалзан шууд хамааралтайгаар өсөж байсан бол сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-уудын тоо нэмэгдсэн хэдий ч харилцагч, үйлчлүүлэгчдийн тоо харьцангуйгаар буурах хандлага ажиглагдаж байна. Иймд ББСБ-уудыг тооноос чанарт шилжүүлэх, тэдгээрийг чадавхижуулах, үүрэг, хариуцлага, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, иргэдийн санхүүгийн салбарт итгэх итгэл, салбарын зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.


(Дүрслэл 2)



Улсын хэмжээнд 518 ББСБ /124 салбар/ тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 11.6 хувь буюу 60 нь хөдөө орон нутагт, 88.4 хувь буюу 458 нь хүн амын төвлөрлөө дагаад Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.


Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын хувьд хүн амын нягтаршил, банк, санхүүгийн үйлчилгээний төвлөрлөө дагаад Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд хамгийн их төвлөрсөн байгаа бол харин Багахангай дүүрэгт одоогоор ББСБ байгуулагдаагүй байна.

(Дүрслэл 3)



Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын хувьд Дорнод, Төв аймгуудад хамгийн их төвлөрсөн байхад Говь-Алтай, Увс, Дорноговь аймгуудад одоогоор ББСБ байгуулагдаагүй байна. Орон нутаг дахь ББСБ-уудын тоо нэмэгдсэнээр иргэдийг бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн үйлчилгээгээр дамжуулан шаардлагатай эх үүсвэрээр дэмжих зэрэг стратегийн чухал ач холбогдолтой бөгөөд улмаар иргэдийн санхүүгийн салбарт итгэх итгэл нэмэгдэж, санхүүгийн боловсрол дээшлэх боломжтой.

(Дүрслэл 4)



ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. АКТИВЫН БҮТЭЦ, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Тайлант жилд ББСБ-уудын актив хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Хүснэгт 7


(мянган төгрөгөөр)

№	ХӨРӨНГӨ	2015		2016		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	600,422,405.4	96.3	754,283,187.5	95.8	153,860,782.1	25.6
1	Мөнгөн хөрөнгө	174,217,117.5	28.0	243,107,520.3	30.9	68,890,402.8	39.5
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	11,856,047.3	1.9	1,302,735.2	0.2	(10,553,312.1)	(89.0)
3	Нийт зээл	391,235,479.1	62.8	478,175,223.3	60.7	86,939,744.2	22.2
	(Зээлийн эрсдлийн сан)	26,556,625.7	4.3	42,065,155.7	5.3	15,508,530.1	58.4
4	Нийт факторингийн тооцооны авлага	30,000.0	-	37,795.0	-	7,795.0	26.0
5	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	30,000.0	-	30,000.0	-	-	-
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	2,726,025.7	0.4	4,480,032.6	0.6	1,754,006.9	64.3
7	Бусад хөрөнгө	46,944,361.5	7.5	69,275,036.9	8.8	22,330,675.4	47.6
B	Эргэлтийн бус хөрөнгө	22,750,118.7	3.7	32,888,822.6	4.2	10,138,703.9	44.6

8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	28,541,236.3	4.6	40,100,706.8	5.1	11,559,470.6	40.5
	(Хуримтлагдсан элэгдэл)	5,791,117.6	0.9	7,211,884.2	0.9	1,420,766.6	24.5
НИЙТ ХӨРӨНГӨ		623,172,524.1	100	787,172,010.1	100	163,999,486.0	26.3

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 787.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 26.3 хувиар өслөө. Энэхүү өсөлт нь Хорооноос 2015, 2016 онд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргасантай шууд холбоотой буюу ББСБ-уудын өөрийн хөрөнгө 154.3 тэрбум төгрөгөөр буюу 36.4 хувиар, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгө 132.1 тэрбум төгрөгөөр буюу 42.8 хувиар өссөн нь голчлон нөлөөлсөн байна. Активын өсөлтийг 2014 оны мөн үетэй харьцуулахад 7.1 нэгж хувиар буурсан бол 2015 оны мөн үеэс 7.8 нэгж хувиар өссөн (Дүрслэл 5)

Нийт активын 95.8 хувийг эргэлтийн хөрөнгө, 4.2 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаагийн 55.4 хувь нь цэвэр зээлийн өрийн үлдэгдэл, 30.9 хувь нь мөнгөн хөрөнгө, 8.8 хувь нь бусад хөрөнгө, үлдэх хэсгийг богино хугацаат хөрөнгө оруулалт, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө тус тус эзэлж байна.



Тайлант оны байдлаар нийт активын 64.9 хувь нь эргэлтэд орж, үлдэх 30.9 хувь нь мөнгөн хөрөнгө хэлбэрээр, 4.2 хувь нь үндсэн хөрөнгө хэлбэрээр байршиж байна. Мөн үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн тайлант үеийн дунджаар тооцвол нийт хөрөнгийн 66.4 хувь нь эргэлтэд орсон байх ба 29.8 хувь нь мөнгөн хөрөнгө хэлбэрээр, 3.8 хувь нь үндсэн хөрөнгө хэлбэрээр байршиж байна.




Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 103.1 тэрбум төгрөг буюу 42.4 хувь нь бэлэн мөнгө, 98.6 тэрбум төгрөг буюу 40.5 хувь нь харилцах, 41.5 тэрбум төгрөг буюу 17.1 хувь нь хадгаламж хэлбэрээр тус тус байршиж байна.

3.2 ЗЭЭЛИЙН БАГЦЫН ЧАНАР

ББСБ-уудын зээлдэгчдийн тоо 66,449-д хүрснээр нийт зээлдэгчдийн 56,171 буюу 84.5 хувийг хэвийн, 3965 буюу 6 хувийг хугацаа хэтэрсэн, 6313 буюу 9.5 хувийг чанаргүй зээлдэгчид эзэлж байна. (Дүрслэл 7)

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх улирлаас 6.8 хувиар буюу 30.8 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 22.2 хувиар буюу 87 тэрбум төгрөгөөр өсч 478.2 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт зээлд эзлэх гадаад валютаар олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.2 тэрбум төгрөгөөр буюу 10.8 хувийн, төгрөгөөр олгосон зээлийн хэмжээ 82.7 тэрбум төгрөгөөр буюу 23.5 хувийн өсөлттэй байна.



Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 8

(мянган төгрөгөөр)


№	Ангилал	2015		2016		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1	Хэвийн	330,712,691.4	84.5	392,017,415.8	82.0	61,304,724.3	18.5
2	Хугацаа хэтэрсэн	22,198,319.9	5.7	26,702,718.9	5.6	4,504,399.0	20.3
3	Чанаргүй зээл: Үүнээс	38,324,467.8	9.8	59,455,088.7	12.4	21,130,620.8	55.1
	Хэвийн бус	10,904,597.0	2.8	12,771,697.0	2.7	1,867,100.0	17.1
	Эргэлзээтэй	10,632,114.9	2.7	18,158,306.1	3.8	7,526,191.2	70.8
	Муу	16,787,755.9	4.3	28,525,085.6	6.0	11,737,329.7	69.9
4	(Зээлийн эрсдэлийн сан)	26,556,625.7	6.8	42,065,155.7	8.8	15,508,530.1	58.4
Нийт зээл		391,235,479.1	100	478,175,223.3	100	86,939,744.2	22.2
1	Үүнээс: Төгрөгөөр олгосон зээл	352,096,434.0	90.0	434,815,431.3	90.9	82,718,997.3	23.5
2	Гадаад валютаар олгосон зээл	39,139,045.1	10.0	43,359,792.0	9.1	4,220,746.9	10.8

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 59.4 тэрбум төгрөгт хүрч, 12.4 хувьд хүрлээ. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 55.1 хувиар өссөн хэдий ч өмнөх улирлаас 5.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Зээлийн эрсдэлийн санд хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ нийт чанаргүй зээлийн 70.8 хувьтай тэнцэж байна.

(Дүрслэл 8)


Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн ангиллын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 21.1 тэрбум төгрөгөөр буюу 55.1 хувиар өссөн явдал нь муу зээлийн хэмжээ 69.9 хувиар өссөнтэй шууд хамааралтай.

Нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь 2014 оны эхнээс 2016 оны гуравдугаар улирлыг хүртэлх хугацаанд 0.3-1.6 хувиар тасралтгүй өсөж байсан бол 2016 оны 4-р улиралд 0.1 функтээр буурсан байна.



ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал:

(Дүрслэл 9)



Хүснэгт 9

Тайлант жилд зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 463 ББСБ-уудаас 24 ББСБ тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг огт эрхлээгүй бөгөөд нийт зээлийн өрийн үлдэгдлийн 34.2 хувийг нэр бүхий 12 ББСБ-ийн зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдэл /интервалиар/	ББСБ тоо	дүн /мян.төг/
10.0-18.4 тэрбум хүртэлх	12	163,312,008.6
5.0-9.9 тэрбум хүртэлх	5	31,442,914.3
1.0-4.9 тэрбум хүртэлх	84	157,659,865.9
500.0-999.9 сая хүртэлх	108	72,005,602.8
100.0-499.9 сая хүртэлх	160	50,821,848.8
1.0-99.9 сая хүртэлх	70	2,932,983.0
Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	23	-
НИЙТ	463	478,175,223.3

Түүнчлэн зээлийн өрийн үлдэгдэл нь 100% чанаргүй ангилалд ангилагдсан нэр бүхий 6 ББСБ-ын 918.2 сая төгрөгийн зээл, 71.4-94.1 хувь нь чанаргүй ангилалд ангилагдсан нэр бүхий 8 ББСБ-ын 11.5 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөл, компанийн гүйцэтгэх удирдлага үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 10

Зээлийн чанар	ББСБ тоо	дүн /мян.төг/
100% чанаргүйдсэн	6	918,168.8
70-95% чанаргүйдсэн	8	11,461,565.2
40-69% чанаргүйдсэн	34	18,560,309.6
10-39% чанаргүйдсэн	75	17,595,122.2
0.1-9.9% чанаргүйдсэн	116	10,919,922.9
Чанаргүй зээлийн ангилалд шилжээгүй	224	-
НИЙТ	463	59,455,088.7

3.3. ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

Тайлант улирлын байдлаар нийт 551.0 тэрбум төгрөгийн зээл олгож, үүнээс 462.5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, нийт зээлийн өрийн үлдэгдэл 478.2 тэрбум төгрөг байна. /Тайлант оны эхний үлдэгдэл 389.7 тэрбум төгрөг байсан/

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл 2016 онд хэрэглээний зээлд 35.8 хувь буюу 197.5 тэрбум төгрөг, худалдааны салбарт 21.8 хувь буюу 120.3 тэрбум төгрөг, уул уурхайн салбарт 17.6 хувь буюу 96.8 тэрбум төгрөг, барилгын салбарт 10.9 хувь буюу 60.1 тэрбум төгрөг бусад салбаруудад 13.9 хувь буюу нийт 76.3 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

(Дүрслэл 10)



Түүнчлэн нийт зээлийн үлдэгдлийн 38.4 хувийг хэрэглээний зээл, 25.7 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбар, 15.1 хувийг барилгын салбар, 4.3 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 3.6 хувийг уул уурхайн салбар, үлдэх 12.9 хувийг бусад салбар тус тус эзэлж байна.

(Дүрслэл 11)




3.4 ЗЭЭЛИЙН ХҮҮ

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 454 ББСБ-ын зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 4.0 хувьд хүрч өмнөх улирлаас 0.2 функтээр буурсан бөгөөд банкны салбарын хүүтэй харьцуулахад хүүгийн зөрүү 2 хувь байна.

Зээлийн хүүг бууруулахад гаднаас хямд өртөгтэй эх үүсвэр татах, үйл ажиллагааны зардлаа бууруулах, зээлдэгчдийн эрсдэлийг үнэлэх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

(Дүрслэл 10)



3.5 АКТИВЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант жилд 16 ББСБ богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгсэлд 1.3 тэрбум төгрөгийг байршуулсны 89.6 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг нэр бүхий 1 компанийн хувьцаагаар хөрөнгө оруулалт дангаараа бүрдүүлж байна. Бусад нэр бүхий 15 ББСБ-ын хувьд 1 сая төгрөгөөс 33.9 сая хүртэлх хэмжээний мөнгөн хөрөнгийг арилжааны болон хөрөнгө оруулалтын үнэт цаасанд байршуулсан байна.

2016 оны байдлаар нэр бүхий 2 ББСБ-ын факторингийн тооцооны авлага данс 37.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас нэр бүхий 1 компанийн 30 сая төгрөгийн авлага муу ангилалд ангилагдан эрсдэлийн сан байгуулсан байна. Тус компани авлагын эрсдэлийн санг 2015 оны хоёрдугаар улиралд байгуулсан хэдий ч "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу шат дараалсан арга хэмжээг авахгүйгээр тайлан тэнцэлд тусгасаар байна. Харин 1 ББСБ-ын 70 сая төгрөгийн факторингийн тооцооны авлагаас 62.2 сая төгрөгийн авлага эргэн төлөгдөж, 7.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 518 ББСБ-ын 40.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөд 7.2 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байх ба хөрөнгийн бүрэлдэхүүнийг харуулбал:

Хүснэгт 11

(мянган төгрөгөөр)

ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	дансны код	32,888,822.6
Үндсэн ба биет бус хөрөнгө		40,100,706,810.5
Барилга байгууламж	1901	13,713,582,910.0
Техник хэрэгсэл	1902	13,064,936,877.4
Тавилга эд хогшил	1903	4,994,115,699.7
Дуусаагүй барилга /үндсэн хөрөнгийн санхүүжилт/	1904	3,801,350,952.6
Биет бус хөрөнгө	1905	4,526,720,370.7
Хуримтлагдсан элэгдэл		7,211,884,207.7
Барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдэл	1911	782,811,965.8
Техник хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл	1912	4,569,929,591.6
Тавилга эд хогшилын хуримтлагдсан элэгдэл	1913	1,859,142,650.3

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

2016 онд ББСБ-уудын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 12

(мянган төгрөгөөр)


№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2015		2016		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
А	Нийт өр төлбөр	198,961,688.0	31.9	208,680,807.4	26.5	9,719,119.4	4.9
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	31,150,371.7	5.0	30,461,357.6	3.9	(689,014.1)	(2.2)
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	125,902,296.2	20.2	121,417,969.1	15.4	(4,484,327.1)	(3.6)
3	Бусад эх үүсвэр	3,103,234.9	0.5	4,118,667.7	0.5	1,015,432.9	32.7
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	515,799.0	0.1	4,080,000.5	0.5	3,564,201.5	691.0
5	Төслийн зээлийн санхүүжилт	14,956,721.3	2.4	21,386,989.0	2.7	6,430,267.8	43.0
6	Бусад өр төлбөр	23,333,264.9	3.7	27,215,823.4	3.5	3,882,558.5	16.6
Б	Өөрийн хөрөнгө	424,210,836.2	68.1	578,491,202.7	73.5	154,280,366.6	36.4
9	Хувьцаат капитал	308,451,260.0	49.5	440,547,491.2	56.0	132,096,231.2	42.8
10	Бусад өмч	12,015,216.9	1.9	6,087,084.4	0.8	(5,928,132.6)	(49.3)
11	Сангууд	330,776.8	0.1	461,368.2	0.1	130,591.3	39.5
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	102,012,229.2	16.4	130,396,503.2	16.6	28,384,274.1	27.8
13	Хоёрдогч өглөг	1,401,353.2	0.2	998,755.8	0.1	(402,597.5)	(28.7)
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	623,172,524.1	100	787,172,010.1	100	163,999,486.0	26.3

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 2016 оны эцэст өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар өсч 208.7 төгрөгт хүрлээ. Эх үүсвэрийн өсөлтөд өрийн бичиг 3.5 тэрбум төгрөгөөр буюу 691 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 6.4 тэрбум төгрөгөөр буюу 43 хувиар өссөн нь голчлон нөлөөлж байна. Түүнчлэн өөрийн хөрөнгө 154.3 тэрбум төгрөгөөр буюу 36.4 хувиар нэмэгдэж, 578.5 төгрөгт хүрэхэд хувь нийлүүлсэн хөрөнгө 132.1 тэрбум төгрөгөөр буюу 42.8 хувиар, хуримтлагдсан ашиг 28.4 тэрбум төгрөгөөр буюу 27.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ББСБ-уудын 2016 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга


(Дүрслэл 12)

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 208.7 тэрбум төгрөг буюу 26.5 хувийг бусдаас татсан эх үүсвэр, 578.5 тэрбум төгрөг буюу 73.5 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байгаагийн 56 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 16.6 хувийг хуримтлагдсан ашиг, 15.4 хувийг банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, 3.9 хувийг итгэлцлийн үйлчилгээний өр, үлдсэн хувийг бусад эх үүсвэр бүрдүүлж байна. 2016 оны тайлант жилийн байдлаарх нийт эх үүсвэрийг 2014, 2015 оны мөн үетэй харьцуулахад харгалзан 34 хувь, 38.1 хувийн бууралттай байгаа бол өөрийн хөрөнгө харгалзан 74.2 хувь, 36.4 хувиар өслөө.



2015 жилийн эцэст нийт өр төлбөр өмнөх улирлаас 1.7 хувиар, 2016 оны гуравдугаар улиралд өмнөх улирлаас 13.9 хувиар тус тус өсөөд байсан бол 2016 оны жилийн эцэст 43.7 хувиар буурсан нь банк, санхүүгийн байгууллагад төлөх өр, итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгө тус тус буурсантай холбоотой байна.

(Дүрслэл 13)



Сүүлийн 1 жилийн хугацаанд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийн тоо өмнөх онуудаас буурсан боловч Хорооноос хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдсээр байна.

ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 132.1 тэрбум төгрөгөөр буюу 42.8 хувиар өссөн үзүүлэлтэд 2016 онд тусгай зөвшөөрөл олгосон 72 компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болох 67.2 тэрбум төгрөг 50.9 хувийг эзэлж байна. Оны эхнээс хувь нийлүүлсэн хөрөнгө 59.5 хувиар, өмнөх улирлаас 9.7 хувиар, хуримтлагдсан ашиг оны эхнээс 27.8 хувиар, өмнөх

улирлаас 9 хувиар тус тус өслөө. 2014-2016 оныг хүртэлх хугацааны хувь нийлүүлсэн хөрөнгийн дундаж өсөлт 8.1 хувь, хуримтлагдсан ашгийн дундаж өсөлт 10.2 хувьтай байна.

14)

ББСБ-ууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээр өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг сайжруулж, мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, улмаар санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ хувь нийлүүлэгчдийн санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх, үйлчилгээний өртгийг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой билээ.



(Дүрслэл)

2016 оны тайлант жилийн байдлаар 800.0 сая төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 240 ББСБ-ын 352.2 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 80 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 13


Хувь нийлүүлсэн хөрөнгө интервалаар	ББСБ тоо	Дүн /мян.төг/	Эзлэх хувь
10-13.9 тэрбум	2	25,362,000.0	5.8%
5.0-7.4 тэрбум	6	40,755,477.0	9.3%
2.5-4.7 тэрбум	22	72,185,393.0	16.4%
1.0-2.4 тэрбум	93	118,409,312.2	26.9%
800.0-999.9 сая	117	95,532,366.4	21.7%
400.0-799.9 сая	179	77,914,027.2	17.7%
100.0-300.0 сая	64	8,594,013.0	2.0%
20.0-80.0 сая	35	1,794,902.4	0.4%
НИЙТ	518	440,547,491.2	100%

Хорооны 2016 оны 72 дугаар тогтоолоор УБ хотод үйл ажиллагаа эрхэлж буй зээл санхүүжилтийн ангиллын ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 800.0 сая төгрөг, хөрөнгө удирдлагын ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2,000.0 сая төгрөг байхаар шинэчлэн тогтоосон бөгөөд 2016 оны жилийн эцэст тогтоолын хэрэгжилт зээл санхүүжилтийн ББСБ-ын хувьд 53.6 хувь, хөрөнгө удирдлагын ББСБ-ын хувьд 44.4 хувьтай гарч тайлан тэнцэлдээ тусгасан байна. Түүнчлэн бусад ББСБ-уудын хувьд тайлант онд багтаан хүсэлтээ ирүүлээд байна.

2016 оны байдлаар итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан 28 ББСБ-ын 21 ББСБ 30.5 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт өрийн 14.6 хувьтай тэнцэж байна. Нэр бүхий 3 ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээний өрийн үлдэгдэл нь харгалзан нийт итгэлцлээр татсан хөрөнгийн 17.7, 16.8, 11.0 хүртэлх хувийг эзэлж байх ба харин нэр бүхий 7 ББСБ итгэлцлийн үйлчилгээ эрхлээгүй байна. Эдгээр 21 ББСБ-уудын нийт хөрөнгө нь салбарын нийт хөрөнгийн 24.5 хувь, өрийн хөрөнгө нь салбарын мөн үзүүлэлтийн 21.0 хувийг тус тус эзэлж байна.

Анхны ББСБ 1999 онд Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авч үүсч байгуулагдсан үеэс хойш итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2004 онд авсан бөгөөд 2016 оныг хүртэлх хугацаанд итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгө, түүний өөрчлөлт дараах байдалтай байна. Үүнд:

(Дүрслэл 15)



Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн жил ирэх тусам өсч байгаа хэдий ч сүүлийн 4 жилийн хугацаанд өсөлтийн хурдац нь харьцангуй саарч байгаа нь дээрх зураглалаас харагдаж байна.

2016 оны тайлант жилд нэр бүхий 4 ББСБ-ын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 980.1 сая төгрөг, 1 компанийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 2.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй

ББСБ-уудын 2016 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

байна. Түүнчлэн нэр бүхий 6 ББСБ нийт 998.8 сая төгрөгийг хоёрдогч өглөгөөр, 7 ББСБ нийт 4.1 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлсэн байна.

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өр, хоёрдогч өглөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгө салбарын нийт өр төлбөрийн 0.5 хувь, төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 1.3 хувь, өрийн бичгээр татан төвлөрүүлсэн хөрөнгө мөн үзүүлэлтийн 2 хувьтай тус тус тэнцэж байна.

5.1 ОРЛОГО

2016 оны жилийн эцэст ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үеэс 23.9 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:

Хүснэгт 16


(мянган төгрөгөөр)

№	ОРЛОГЫН ТӨРӨЛ	2015		2016		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1	Хүүгийн орлого	119,770,175.0	76.7	135,610,491.3	70.1	15,840,316.3	13.2
2	Хүүгийн бус орлого	33,373,031.9	21.4	54,350,621.9	28.1	20,977,590.0	62.9
3	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,959,574.1	1.9	3,464,896.4	1.8	505,322.2	17.1
4	Ердийн бус орлого	-	-	-	-	-	-
НИЙТ ОРЛОГО		156,102,781.0	100	193,426,009.6	100	37,323,228.6	23.9

Нийт орлогын 70.1 хувийг хүүгийн орлого, 28.1 хувийг хүүгийн бус орлого, 1.8 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлого бүрдүүлж байна. Хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар, хүүгийн бус орлого 62.9 хувиар, ердийн бус орлого 17.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарлаа. Нийт орлогын 70.1 хувийг бүрдүүлж буй хүүгийн орлогын өсөлтийн хурдац 2014 оны мөн үеэс 22.8 хувиар, оны эхнээс 20.1 хувиар саарсан үзүүлэлттэй байгаа бол хүүгийн бус орлогын хувьд 2014 оны жилийн эцсээс 82.7 хувиар, оны эхнээс 57 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

(Дүрслэл 15)

2016 оны байдлаар нийт хүүгийн орлогын 128.1 тэрбум төгрөг буюу 94.5 хувийг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого, 5.6 тэрбум төгрөг буюу 4.1 хувийг хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого бүрдүүлж байгаа бол хүүгийн бус орлогын 39.8 тэрбум төгрөг буюу 73.2 хувийг ханшийн тэгштгэлийн орлого, 10.7 тэрбум төгрөг буюу 19.6 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого, 3.9 тэрбум төгрөг буюу 7.2 хувийг гадаад валютын арилжааны орлого, үндсэн бус үйл ажиллагааны орлогын 1.7 тэрбум төгрөг буюу 48.7 хувийг бусад орлого, 1.1 тэрбум төгрөг буюу 32.9 хувийг торгууль, алдангийн орлого, 0.6 тэрбум төгрөг буюу 16.1 хувийг тэнцлийн гадуурх тооцооны эргэн төлөлт, үлдэх хэсгийг үндсэн хөрөнгө борлуулсаны орлого тус тус эзэлж байна.



5.2 ЗАРДАЛ

2016 оны жилий эцэст нийт зардал өмнөх оны мөн үеэс 22.5 хувиар өссөн ба дараах үндсэн бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Хүснэгт 17

(мянган төгрөгөөр)

№	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2015		2016		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1	Хүүгийн зардал	14,931,386.0	13.6	15,367,728.1	11.4	436,342.1	2.9
2	Хүүгийн бус зардал	71,268,198.0	65.0	88,918,222.8	66.2	17,650,024.8	24.8
3	Болзошгүй эрсдэлийн зардал	16,433,280.6	15.0	21,185,880.9	15.8	4,752,600.3	28.9
4	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	940,463.1	0.9	1,874,226.1	1.4	933,763.0	99.3
5	Орлогын татварын зардал	6,141,944.3	5.6	7,026,876.5	5.2	884,932.2	14.4
НИЙТ ЗАРДАЛ		109,715,271.9	100	134,372,934.4	100	24,657,662.5	22.5

Нийт зардлын 88.9 тэрбум төгрөг буюу 66.2 хувийг хүүгийн бус зардал, 21.2 тэрбум төгрөг буюу 15.8 хувийг болзошгүй эрсдэлийн сангийн зардал, 15.4 тэрбум төгрөг буюу 11.4 хувийг хүүгийн зардал, 7 тэрбум төгрөг буюу 5.2 хувийг орлогын албан татварын зардал бүрдүүлж байна. Нийт зардал өмнөх оны мөн үеэс 22.5 хувиар, үүний дотор хүүгийн зардал 2.9 хувиар, хүүгийн бус зардал 24.8 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 28.9 хувиар, орлогын татварын зардал 14.4 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 99.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарлаа.

Хүүгийн бус зардлын 37.7 хувийг арилжааны болон ханшийн тэгштгэлийн зардал, 32.1 хувийг боловсон хүчний зардал, 30.2 хувийг бусад зардал эзэлж байна.

2014-2016 оныг хүртэлх хугацаанд хүүгийн зардал буурч байхад үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардал өссөн үзүүлэлттэй байна.

5.3 АШИГТ АЖИЛЛАГАА


Тайлант хугацаанд 59.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 12.7 тэрбум төгрөгөөр буюу 27.3 хувиар, өмнөх улирлаас 14.8 тэрбум төгрөгөөр буюу 33.4 хувиар өссөн нь актив хөрөнгө 26.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 18

(мянган төгрөгөөр)


№	Үзүүлэлт	2015 IV улирал		2016 IV улирал		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1	Нийт орлого	156,102,780.9	100	193,426,009.6	100	37,323,228.7	23.9
2	Нийт зарлага	109,715,271.9	100	134,372,934.4	100	24,657,662.5	22.5
ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ		46,387,509.0		59,053,075.1		12,665,566.1	27.3

(Дүрслэл 16)



ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулбал:

(Дүрслэл 17)



2011-2013 оныг хүртэлх хугацаанд ашгийн өсөлт дунджаар 61.3 хувьтай байсан бол 2014-2016 оныг хүртэлх хугацаанд 25.7 хувьд хүрч 35.6 хувиар буурсан байна.

Салбарын хэмжээнд нийт 518 ББСБ-ын 80.3 хувь буюу 416 ББСБ 63.9 тэрбум төгрөгийн ашигтай, 4.1 хувь буюу 21 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 15.6 хувь буюу 81 ББСБ 4.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

ЗУРГАА. САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

6.1 ОРОН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ ББСБ

Тайлант онд орон нутагт төвтэй 60 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаа нь 2015 оны мөн үеэс 10 компаниар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-ын 55 ББСБ нь зээл санхүүжилтийн, 2 ББСБ валют арилжааны, 3 ББСБ хөрөнгө удирдлагын ББСБ-ын ангилалд хамрагдан үйл ажиллагаа эрхэлж байна.

Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын актив хөрөнгө нь салбарын нийт активын 2.4 хувь, зээлийн өрийн үлдэгдэл нь 2.9 хувь, өөрийн хөрөнгө нь 3.2 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3.3 хувьтай тус тус тэнцэж байна. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын тооны өөрчлөлттэй холбогдуулан оны эхнээс нийт актив 15.8 хувь, нийт зээл 8.8 хувь, өөрийн хөрөнгө 35.5 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө 70.8-ийн өсөлттэй гарлаа. Үүнд:

Хүснэгт 19

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015	2016	Өсөлт +/- бууралт +/-
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	50	60	10
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	11.1%	11.6%	20.0%
А	Нийт актив	16,622,688.8	19,243,197.1	2,620,508.3
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	2.7%	2.4%	15.8%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	12,561,732.7	13,662,846.6	1,101,113.9
	ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	3.2%	2.9%	8.8%
	Чанаргүй зээл	571,542.5	1,082,115.4	510,572.9
	ББСБ-ын нийт чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	1.6%	1.8%	89.3%
В	Нийт өөрийн хөрөнгө	13,580,419.4	18,407,891.1	4,827,471.72
	ББСБ-ын нийт эздийн өмчид эзлэх хувь	3.2%	3.2%	35.5%
Г	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	8,391,032.4	14,332,489.8	5,941,457.42
	ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь	2.7%	3.3%	70.8%

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өсөлттэй байгаа хэдий ч чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 89.3 хувиар өссөн явдал нь нэр бүхий 4 ББСБ-ын нийт зээлийн 33.2-60.4 хувь нь чанаргүй зээлийн ангилалд шилжсэнтэй холбоотой.

Хорооноос орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бичил санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх үндсэн зорилтын хүрээнд орон нутаг дахь төлөөлөгчдөд зориулсан сургалт, семинарыг тогтмол зохион байгуулж, иргэдэд чиглэсэн мэдээлэл, заавар, зөвлөмжийг тухай бүр өгч ажиллаж байгаагийн дүнд сүүлийн жилүүдэд орон нутагт үйл ажиллагаа эрхлэх ББСБ-ын тоо нэмэгдсээр байна. Тоо баримтаас үзэхэд УБ хотод төвтэй 13 ББСБ орон нутагт 32 салбар, 2 төлөөлөгчийн газартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

6.2 ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ББСБ

Тайлант улиралд гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 30 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 5.8 хувь, тэдгээрийн актив нь салбарын 15.9 хувь, зээлийн өрийн үлдэгдэл нь салбарын 17.2 хувь, өөрийн хөрөнгө нь салбарын 11.1 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь салбарын 11.7 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 20

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015	2016	өсөлт +/-,
				бууралт +/-
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	27	30	3
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>6.0%</i>	<i>5.8%</i>	<i>11.1%</i>
А	Нийт актив	96,636,673.1	124,962,317.5	28,325,644.4
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>15.5%</i>	<i>15.9%</i>	<i>29.3%</i>
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	72,099,576.3	82,449,769.6	10,350,193.3
	Үүнээс: Чанаргүй зээл	8,166,114.7	12,473,761.0	4,307,646.3
	<i>Нийт ББСБ-ын зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>18.4%</i>	<i>17.2%</i>	<i>52.8%</i>
В	Нийт өөрийн хөрөнгө	56,622,947.3	64,005,180.3	7,382,233.0
	<i>ББСБ-ын нийт эздийн өмчид эзлэх хувь</i>	<i>13.3%</i>	<i>11.1%</i>	<i>13.0%</i>
Г	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	41,477,491.9	51,642,766.6	10,165,274.7
	<i>ББСБ-ын нийт хувь хөрөнгөд эзлэх хувь</i>	<i>13.4%</i>	<i>11.7%</i>	<i>24.5%</i>

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 11, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 6, Хонг Конгийн хөрөнгө оруулалттай 3, АНУ-ын хөрөнгө оруулалттай 2, Хятад, Орос, Сичель, Франц, Англи, Люксембург, Малайз, Швейцарийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

6.3 ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА ЭРХЛЭН ЯВУУЛЖ БУЙ ББСБ

Хорооноос 2016 онд 2 компанид гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 2 ББСБ-д нэмж олгох, 2 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацааны эцэст Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 518 ББСБ-ын 27.8 хувь буюу 144 ББСБ гадаад валютын арилжаа эрхэлж байгаагийн 35.4 хувь буюу 51 компани нь дагнан эрхэлж байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын санхүүгийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 22

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны	2016 оны	өсөлт +/-,
		IY улирал	IV улирал	бууралт +/-
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагааг эрхэлж буй ББСБ-ын тоо	52	51	-1
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>11.6%</i>	<i>9.8%</i>	<i>-1.9%</i>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	11,173,674.2	10,548,982.6	(624,691.6)

ББСБ-уудын 2016 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

ББСБ-ын нийт активт эзлэх хувь		1.8%	1.3%	-5.6%
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	10,817,889.5	10,356,667.7	(461,221.8)
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		2.6%	1.8%	-4.3%
В	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мянган төгрөгөөр/	9,277,550.0	9,524,076.4	246,526.4
ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь		3.0%	2.2%	2.7%

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 2.7 хувийн өсөлттэй байгаа хэдий ч өөрийн хөрөнгө, нийт актив харгалзан 4.3 хувь, 5.6 хувиар буурсан нь ББСБ-уудын тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлттэй шууд хамааралтай байна.

Валют арилжааны мэдээ ирүүлсэн ББСБ-ууд тоо мэдээнээс үзэхэд тайлант онд нийт 990.3 тэрбум төгрөгийн валют худалдан авч, 1,017.3 тэрбум төгрөгийн валют худалсан байна. Нийт худалдаж авсан валютын 46.6 хувь буюу 461.8 тэрбум төгрөгт ам.доллар, 38.8 хувь буюу 384.5 тэрбум төгрөгт юань, 6.6 хувь буюу 65.5 тэрбум төгрөгт евро тус тус худалдаж авсан бол нийт зарсан валютын 45.8 хувь буюу 446.4 тэрбум төгрөгт ам.доллар, 40.1 хувь буюу 407.5 тэрбум төгрөгт юань, 6.3 хувь буюу 63.8 тэрбум төгрөгт евро тус тус зарсан байна.

Хүснэгт 23

(мянган төгрөгөөр)

№	Худалдаж авсан		Худалдсан	
1	АНУ-ын доллар	461,874,120.0	АНУ-ын доллар	466,425,110.1
2	ОХУ-ын рубль	24,846,500.9	ОХУ-ын рубль	25,515,271.2
3	БНХАУ-ын юань	384,519,218.6	БНХАУ-ын юань	407,565,587.3
4	БНСУ-ын вон	20,065,173.0	БНСУ-ын вон	18,858,729.8
5	Евро	65,518,860.9	Евро	63,872,373.5
6	Японы иен	21,528,297.9	Японы иен	22,636,869.9
7	Казакстаны тэнгэ	340.8	Казакстаны тэнгэ	397.6
8	Английн фунт	5,361,013.4	Английн фунт	5,301,031.8
9	Австралийн доллар	1,189,142.6	Австралийн доллар	1,139,927.4
10	Сингапурын доллар	761,725.1	Сингапурын доллар	740,097.4
11	Хонконг доллар	1,917,141.0	Хонконг доллар	1,846,668.7
12	Канадын доллар	256,158.0	Канадын доллар	268,024.1
13	Швейцарь франк	1,917,505.4	Швейцарь франк	1,412,832.1
14	Энэтхэгийн рупи	88,550.8	Энэтхэгийн рупи	117,979.0
15	Шведийн крон	247,271.7	Шведийн крон	248,355.8
16	Тайван доллар	14,196.4	Тайван доллар	1,360.0
17	БНАСАУ-ын вон	91,219.8	БНАСАУ-ын вон	1,289,278.4
18	Чех крон	8,284.8	Чех крон	7,737.3
19	Тайланд бат	5,352.0	Тайланд бат	7,521.2
20	Малайзын ринггит	73,916.7	Малайзын ринггит	49,615.0
21	Индонезийн рупп	1,282.8	Индонезийн рупп	1,640.1
НИЙТ		990,285,272.4	НИЙТ	1,017,306,407.6

ДОЛОО. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч ББСБ-ын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу тооцож үзэхэд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 24

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	427	82.4
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	60	11.6
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	19	3.7
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	6	1.2
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.4
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	4	0.7

ББСБ-уудын 2016 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

НИЙТ	518	100
-------------	------------	------------

7.1 ВАЛЮТ АРИЛЖААНЫ ББСБ-ЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ*Хүснэгт 25*

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	51	94.4
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	3.7
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	1.9
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
НИЙТ		54	100

Валют арилжааны ББСБ-уудын тооцвол зохих зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

- 1) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 53 ББСБ хангасан буюу биелэлт 98.1 хувь;
- 2) өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлагыг 53 ББСБ хангасан буюу биелэлт 98.1 хувь;
- 3) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлага бүрэн;
- 4) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 53 ББСБ хангасан буюу биелэлт 98.1 хувь;
- 5) үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлагыг 53 ББСБ хангасан буюу 98.1 хувь;
- 6) өрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Валют арилжааны 54 ББСБ-ын хувьд 1 ББСБ-ын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 25.2 хувиар, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 35.2 хувиар, тус тус 1 ББСБ-ын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 5.6 хувиар үндсэн хөрөнгийн зохистой харьцааг 9.2 хувиар алдагдсан байна.

7.2 ЗЭЭЛ САНХҮҮЖИЛТИЙН ББСБ-ЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ*Хүснэгт 26*

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	340	81.7
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	51	12.3
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	16	3.8
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	0.7
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.5
6	5-6 дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	4	1.0
НИЙТ		416	100

Зээл санхүүжилтын ББСБ-ын тооцвол зохих 14 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

- 1) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 409 ББСБ хангасан буюу биелэлт 98.3 хувь;
- 2) өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 409 ББСБ хангасан буюу биелэлт 98.3 хувь;

- 3) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 412 ББСБ хангасан буюу биелэлт 99.0 хувь;
- 4) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 403 ББСБ хангасан буюу биелэлт 97 хувь;
- 5) активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг 415 ББСБ хангасан буюу биелэлт 99.8 хувь;
- 6) нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 392 ББСБ хангасан буюу биелэлт 94.2 хувь;
- 7) нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн хэмжээ 10 хувиас ихгүй байх шаардлагыг 407 ББСБ хангасан буюу биелэлт 97.8 хувь;
- 8) нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлагыг 411 ББСБ хангасан буюу биелэлт 98.9 хувь;
- 9) үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас ихгүй байх шаардлагыг 415 ББСБ хангасан буюу биелэлт 99.8 хувь;
- 10) нэг компаниас худалдан авах үнэт цаасны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
- 11) ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлагыг бүрэн;
- 12) гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлага 388 ББСБ хангасан буюу биелэлт 93.3 хувь;
- 13) цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг 395 ББСБ хангасан буюу биелэлт 95.0 хувь;
- 14) өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй байх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Зээл санхүүжилтийн 416 ББСБ-ын хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа, нэг этгээд олгох зээлийн төвлөрөл, гадаад валютын позиц, үндсэн хөрөнгийн харьцаа үзүүлэлтүүдийг 13-28 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

7.3 ХӨРӨНГӨ УДИРДЛАГЫН ББСБ-ЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 27

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	36	75.0
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	7	14.6
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	4.2
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	6.2
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
НИЙТ		48	100

Хөрөнгө удирдлагын ББСБ-ын тооцвол зохих 18 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

- 1) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлагыг бүрэн;
- 2) өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг бүрэн;
- 3) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9 хувь;
- 4) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 43 ББСБ хангасан буюу биелэлт 89.6 хувь;
- 5) активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлт бүрэн;

ББСБ-уудын 2016 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

- 6) нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 45 ББСБ хангасан буюу биелэлт 93.7 хувь;
- 7) нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн хэмжээ 10 хувиас ихгүй байх шаардлагыг 45 ББСБ хангасан буюу биелэлт 93.7 хувь;
- 8) нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9 хувь;
- 9) үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 50 хувиас ихгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9 хувь;
- 10) худалдан авах хувьцааны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9 хувь;
- 11) нэг компаниас худалдан авах хувьцааны төвлөрлийн үзүүлэлт өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;
- 12) өрийн бичгийн эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
- 13) хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа 20 хувиас ихгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9 хувь;
- 14) ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлагыг бүрэн;
- 15) гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлага 45 ББСБ хангасан буюу биелэлт 93.7 хувь;
- 16) итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн зохистой харьцаа 80 хувиас ихгүй байх шаардлага бүрэн;
- 17) цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг 47 ББСБ хангасан буюу биелэлт 97.9 хувь;
- 18) өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй айх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Хөрөнгө удирдлагын 47 ББСБ-ын хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа, нэг этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт, гадаад валютын позицын харьцаа үзүүлэлтийг 3-5 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

Дүгнэлт: 2016 оны байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 518 ББСБ-ын 427 ББСБ буюу 82.4 хувь нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан бол 60 ББСБ буюу 11.6 хувь нь 1 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 19 ББСБ буюу 3.7 хувь нь 2 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 6 ББСБ буюу 1.2 хувь нь 3 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 6 ББСБ буюу 1.2 хувь нь 4-өөс дээш харьцаа үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.

НАЙМ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

1. 2016 онд нийт 396 ББСБ-аас 572,659.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 388 ББСБ 573,973.0 мянган төгрөгийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн буюу 8 ББСБ 7,960.0 мянган төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөөгүйгээс биелэлт 97.9 хувьтай байна.
2. Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүргийг тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 454 ББСБ-ын 76 хувь буюу 345 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.
3. Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх үүргийг тайлант улиралд 450 ББСБ-ын 68.9 хувь буюу 310 ББСБ хэрэгжүүлсэн байх тул Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15.4 дэх хэсгийн "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь жилийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд нэр бүхий 2 ББСБ 11 удаагийн тохиолдлоор 540.8 сая төгрөгийн сэжигтэй гүйлгээ, 107 ББСБ 5832 удаагийн тохиолдлоор 196,037.4 сая төгрөгийн 20 сая төгрөгөөс дээш гүйлгээг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

БС. ДҮГНЭЛТ

Тусгай зөвшөөрөлтэй 518 ББСБ-дын 96.1 хувь нь буюу 498 ББСБ 2016 оны IV улирлын байдлаар тайлан, мэдээгээ зохих журмын дагуу ирүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар, өмнөх улирлаас 0.4 хувиар нэмэгдсэн байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 1.3 дахь хэсэгт заасан ангиллын хүрээнд тайлант хугацаанд валют арилжааны чиглэлийн 54, зээл, санхүүжилтийн чиглэлийн 416, хөрөнгийн удирдлагын 48, нийт 518 ББСБ тусгай зөвшөөрөлтэй байгаагийн 11.6 хувь буюу 60 нь хөдөө орон нутагт, 88.4 хувь буюу 458 нь хүн амын төвлөрлөө дагаад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүн нэгтгэлээрх нийт активын төвлөрлийг харахад 10.0 тэрбум төгрөгөөс дээш активтай 15 ББСБ-ын 266.1 тэрбум төгрөгийн актив нь нийт активын 33.8 хувийг, 5.0 тэрбумаас 8.4 тэрбум хүртэлх төгрөгийн активтай 11 ББСБ-ын 75.9 тэрбум төгрөгийн актив нь нийт активын 9.6 хувийг, 1.0 тэрбумаас 4.8 тэрбум хүртэлх төгрөгийн активтай 128 ББСБ-ын 251.5 тэрбум төгрөгийн актив нь нийт активын 32 хувийг, 400.0 сая төгрөгөөс 999.0 сая хүртэлх төгрөгийн активтай 253 ББСБ-ын 176.7 тэрбум төгрөгийн актив нь нийт активын 22.4 хувийг, 20.0 сая төгрөгөөс 399.0 сая төгрөгийн активтай 111 ББСБ-ын 16.9 тэрбум төгрөгийн актив нь нийт активын 2.1 хувийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл 151 ББСБ буюу нийт ББСБ-ын 29.1 хувь нь нийт активын 75 хувийг эзэлж байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт актив 787.2 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.1 хувь, зээлийн өрийн үлдэгдэл 478.2 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.9 хувь, өөрийн хөрөнгө 578.5 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 18.6 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө 440.5 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 68.8 хувьтай тус тус тэнцэж байна.

Нийт активын 60.8 хувийг зээлийн өрийн үлдэгдэл, 30.9 хувийг мөнгөн хөрөнгө /эдгээр нь нийт активын 91.7 хувь/ эзэлж байгаагаас үзэхэд банк бус санхүүгийн байгууллагууд зээлийн үйл ажиллагаанаас бусад санхүүгийн ажил үйлчилгээг эрхлэх замаар сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөө зөв оновчтой удирдан зохион байгуулж, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой байна.

Түүнчлэн Монгол улсын эдийн засгийн бууралт, иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, зээлийн чанартай холбоотойгоор тайлант үеийн байдлаар нийт 243.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаагаас /19.4 тэрбум төгрөг төлбөр түргэн гүйцэх чадварт нөөцлөгдөж, 10.2 тэрбум төгрөг буюу 4.2 хувийг валют арилжаа дагнан эрхэлж байгаа ББСБ-д байршсан/ 213.5 тэрбум төгрөг буюу 87.8 хувь эргэлтэд ороогүй байна.

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 59.4 тэрбум төгрөгөөр өсч, 12.4 хувьд хүрлээ. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 55.1 хувиар өссөн хэдий ч өмнөх улирлаас 5.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн ангиллын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 21.1 тэрбум төгрөгөөр буюу 55.1 хувиар өссөн явдал нь муу зээлийн хэмжээ 69.9 хувиар өссөнтэй шууд хамааралтай байна.

Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр ББСБ-ууд нь 100 төгрөгийн өөрийн хөрөнгөөс 69 төгрөгийн ашиг олж байгаа ба салбарын хэмжээгээр ББСБ-уудын активын өгөөж 8.4 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 11.8 хувьтай байна.

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 73.5 хувийг буюу 578.5 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгөөр, 15.4 хувийг буюу 121.4 тэрбум төгрөгийг дотоод гадаадын банк санхүүгийн байгууллага, төслийн зээлийн санхүүжилтээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр, 3.9 хувь буюу 30.4 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээний өглөгөөр бүрдүүлж байгаа нь ББСБ-ууд системийн хэмжээгээр өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулдаг онцлогтой холбоотой.

Нийт ББСБ-ын 416 ББСБ буюу 80.3 хувь нь 63.9 тэрбум төгрөгийн ашигтай, 81 ББСБ буюу 15.6 хувь нь 4.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол харин 21 ББСБ буюу 4.1 хувь нь үйл ажиллагаа эрхлээгүй бөгөөд системийн хэмжээгээр тайлант хугацаанд нийт 59.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12.7 тэрбум төгрөгөөр буюу 27.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР